

ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД


*ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн газрын
Цагдаа судлалын тэргийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
докторант, цагдаагийн ахмад Б.Мөнхдорж*

БНСУ-ЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДЭЛЭЖ БҮЙ АРГА ТҮРШЛАГА

БНСУ нь хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг нэгтгэх ажлыг 2005 онд эхлэн 2010 оноос албан ёсоор ял ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Монгол Улс мөн адил хууль сахиулах ял ажиллагааны мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх талаар ажиллаж байна.

Эрүүгийн хэргийн нэгдсэн системд (**The office of criminal justice information system**) цагдаа, прокурор, хууль зүйн яам, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн байгууллагуудын эрүүгийн хэргийн ял ажиллагааны талаарх мэдээллийн системийг нэгтгэжээ.



The office of criminal justice information system only in the Operations and Management

БНСУ-ын Эрүүгийн хэргийн мэдээллийн нэгдсэн системийн ерөнхий схем./Товчилсон нэр: KICS/

БНСУ нь анх хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн систем хийж, нэгдсэн байдлаар бүрдүүлэх зорилго тавьсан ч зарим байгууллагын амбицаас шалтгаалаад мэдээллийн нэгдсэн солилцооны буюу мэдээллийг уялдуулсан систем бүрдүүлсэн гэж байв. Мөнд шүүх нь бүрэн хэмжээгээр ороогүй байлаа.

Мэдээллийн нэгдсэн системийг бий болгоход хууль сахиулах байгууллагуудын орлогч дарга нараас бүрдсэн орон тооны бус зөвлөл ажилладаг бөгөөд тухайн байгууллага бүрээс 1Т-гийн болон статистикийн мэргэжлийн 2 хүн, нийтдээ 10-аад хүн энэ системийг бий болгоход хүчин зүтгэсэн, харьяа агентлагаас 2 жилийн хугацаагаар томилогдон ажилладаг. Харин програм хангамж, түүний засвар, үйлчилгээг хувийн хэвшлээр хийлгүүлдэг (LG компани) байна.

Эрүүгийн хэргийн нэгдсэн системийг удирдлага, зохион байгуулалтын хувьд Хууль зүйн яам нь хариуцан ажилладаг бөгөөд уг системийг нэвтрүүлснээр цаасаар

ажлаа хийх явдал багассаж, Үйл ажиллагаа нь цахимжсан, хурдассан, шударга ёс тодорхой хэмжээнд хангагджээ.

Уг нэгдсэн системийг бий болгохын тулд эрх зүйн орчин буюу хууль, журмыг боловсруулан батлуулах, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн сангийн нөхцөл байдалд судалгаа хийх, системээ боловсруулах, нэгжүүдээ сэлжээнд холбох зэрэг ажлуудыг Үе шаттайгаар нэгэн зэрэг 2005 оноос эхлэн 4 жил орчим хийсний дүнд 2010 оны 7 сард албан ёсоор Үйл ажиллагаагаа эхлүүлсэн байв.

Энэхүү эрүүгийн хэргийн нэгдсэн систем, түүн дэх мэдээллийн баазад ндэслэн иргэдэд зориулсан **portal** сайт ажиллуулж байна. Үүгээр хууль сахиулах байгууллагын Үйл ажиллагааг иргэдэд хяргэх, хянгын зэргийн хэргийг заавал оролцогчдыг ирүүлэхгүйгээр цахим хэлбэрээр шийдэх, торгуулийг үүгээр дамжуулан онлайнаар төлөх, шүүх хуралдааны зар, шүүрийнхүү хэргийн Үйл явц аль шатандаа яваа зэрэг мэдээллийг иргэд уг сайтаас авах боломжтой. Уг системд ндэслэсэн 74 төрлийн Үйлчилгээиргэдэд хяргэдэг байна.

Мэдээллийн систем 400 гаруй төрлийн мэдээллийн сангаасбүрддэг ба энэ нь зөвхөн эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээллийн сан байна. БНСУ нь захиргааны зөрчил, гэмт хэргийг нийтэд эрүүгийн хэрэг гэж авч үздэг онцлогтой. Мөн шүүхэд гарсан иргэний болон захиргааны хэрэг, маргааны мэдээлэл үүнд ороогүй болно.

Уг системд оруулах мэдээллийн агуулга, стандартыг тухайн байгуулагдсан зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулдаг бөгөөд мэдээллийн сангаас цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бүр шүүрсдийнхүү эрхээр орж, Үйл ажиллагааны статистик мэдээллээ гарган авч, дүн шинжилгээ хийдэг байна.

Цаашид эрүүгийн хэргийн мэдээллийн нэгдсэн системд шүүхийн байгууллагуудыг бүрэн татан оруулах, гэмт хэргийн хохирогчдод зориулсан портал сайт ажиллуулах, системийг хурдан болгох, төрийн бусад мэдээллийн сантай бүрэн уялдуулах, портал сайтаас smart note, гар утсаараа иргэд мэдээлэл авах, Үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх техникийн шийдлийг сайжруулахаар ажиллаж байна.

БНСУ-ын эрх зүйн тогтолцоо, Хууль зүйн яам, Төрийн хууль тогтоомжийн яам, хууль сахиулах байгууллагуудын Үйл ажиллагаа манай улсаас бүр, бүрмөц онцлогтой. Тус улс нь дэд бүтэц, мэдээллийн технологи үндэр хөгжсөн, энэ төрлийн Үйлдвэрлэгч орон учраас хууль сахиулах байгууллагуудын Үйл ажиллагаанд мэдээллийн технологи гүнзгий нэвтэрч, бодит хэрэглээ болгож чаджээ.

Манай улс тус улсын эрх зүйн тогтолцоо, **хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийн** талаар авах туршлага их байна. Энхүү системийг бий болгоход манай сургуулиас 1Т-ийн шийдэл, системийг боловсруулахад оролцох, ямар мэдээллээр нэгдсэн сан бүсгэх, тэрхүү мэдээллийн маягтын стандарт, агуулга нь ямар байх, байгууллага бүр хоорондоо ямар мэдээлэл солилцох боломжтой, сангаас Үйл ажиллагааны бүр дүнг илэрхийлсэн статистикийн мэдээллийг байгууллага бүр ямар үзүүлэлтээр хэрхэн авах боломжтой талаар оролцох нь зүйтэй.

Жуич: <http://fgn.kics.go.kr/en/> цахим хаягаар дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.